



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 779

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9 нэрийн нийт 77,962,082.00 (далан долоон сая есөн зуун жаран хоёр мянга наян хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах, ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201777

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн
479 дугаар тогтоолын хавсралт

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ	Хуримт- лагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					(төгрөг)	
Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж						
1	48 В-ын тэжээлийн системийн аккумулятор	2007-12-31	1.00	3,532,594	3,532,594	-
2	Аккумулятор FM300G 2V, 300A	2007-12-32	1.00	7,554,835	7,554,835	-
3	Мульти плексор PMX-3004	2007-12-31	1.00	3,965,289	3,965,289	-
4	Синхрон дамжуулалтын төхөөрөмж STM-1	2007-12-31	1.00	40,805,203	40,805,203	-
5	GPS актив антенн /ДҮТ-ийн дээвэрт суурилуулсан/	2007-12-32	1.00	3,091,000	3,091,000	-
6	Цагийн дохио үүсгэгч систем hopt System 7001 19 инчийн суурьтай	2007-12-33	1.00	14,840,308	14,840,308	-
7	Электрон тоолуур	2007-12-31	1.00	1,390,950	1,390,950	-
8	Электрон тоолуур	2007-12-31	1.00	1,390,951	1,390,951	-
9	Электрон тоолуур	2007-12-31	1.00	1,390,952	1,390,952	-
НИЙТ ДҮН				77,962,082	77,962,082	-
				(далан долоон сая есөн зуун жаран хоёр мянга наян хоёр)		